



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/22.

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэнхэрмандал сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

| | | |
|-----------------------|--------------|---|
| Дарга: | Ж.Гантулга | -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Н.Үнэнбат | -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүн: | Д.Цэцэгсүрэн | -Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн |

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР